

**Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Сан, Олон Улсын Цөмийн
Энергийн Агентлаг, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндсэний төвөөс хамтран
зохион байгуулсан**

**Монгол Улсад хүүхдийн дүрс оношилгооны чадавхийг сайжруулах үндэсний
сургалтын тайлан**

2025 оны 09 сарын 27-ноос 10 сарын 02

ЭМЯ, НҮБ-ын Хүүхдийн сан, Олон Улсын Цөмийн Энергийн Агентлаг болон ЭХЭМҮТ-ийн Эрдэм шинжилгээ, гадаад харилцааны алба, НЭМСА, ЭХЭМҮТ-ийн Радиологийн Тасагтай хамтран “Монгол улсад хүүхдийн дүрс оношилгооны чадавхийг сайжруулах үндэсний сургалт”-ыг 21 аймаг, ШУГТЭ, УНТЭ, МЯСЭ, 9 дүүргийн эмнэлэгүүд, нийслэлийн амаржих газрууд болон хувийн томоохон эмнэлэгүүдийн хүүхдийн дүрс оношилгооны эмч, технологич нарыг хамруулан 2025 оны 9 дүгээр сарын 27-ноос 10 дугаар сарын 02 ны өдрийг дуустал онол дадлага хосолсон танхим болон цахимаар амжилттай зохион байгууллаа. Нийт 266 оролцогчид оролцож багц цагаа авсан.

Тус сургалтаар Хүүхэд бол жижиг насанд хүрсэн хүн биш болохыг батлах анатоми, физиологийн онцлог, оношилгооны нарийн ялгаа зэргийг гүнзгийрүүлэн судлахаас гадна хүүхэд эцэг эхтэй зөв боловсон харилцах, хүүхдийн дүрс оношилгооны үйлчилгээг зөв зохион байгуулах, цацрагийн хамгаалалт, хиймэл оюуны шинэ хэрэглээг нэвтрүүлэх зэрэг чухал сэдвүүдийг хөндөж эмч нар болон технологич нарт 3 хоногийн турш онолын мэдээлэл лекц хэлбэрээр танхим болон онлайнаар явуулсан. Дөрөв дэх өдрийн дадлага сургалтын эхний хэсэгт толгой, нуруу, нугас, хэвлий, үе зөөлөн эдийн хэт авиан шинжилгээ хийх арга техник удирдамжыг танилцуулж зочин экспертээр менингиоцеле оноштой нярай хүүхдэд үзлэг хийж хэлэлцүүлэг явуулсан. Оролцогч нар нийт 6 хүүхдэд дээрх шинжилгээнүүдийг хийж санал солилцсон. Хүүхдийг үзэхийн өмнө эцэг эхээс бичгээр зөвшөөрөл авч халдвар хамгааллын дэглэм болон ёс зүйн хэм хэмжээг баримтлан зохион байгуулсан. Хоёр дахь хэсэгт дүрс оношилгооны эмч нарт хэт авиан хяналтан доор биопси хийх арга техник, ач холбогдлыг практик хэлбэрээр үзүүлэн дадлага хийж ажилласан. Дадлагыг урьдчилан бэлтгэсэн фантомууд болон зочин экспертүүдийн авчирсан фантомууд дээр явагдсан. Дүрс оношилгооны технологич нарт ЭХЭМҮТ болон ШУГТЭ-ийн Радиологийн тасагт КТГ болон СРТ аппаратууд дээр зүрх судас, мэдрэл болон хоол боловсруулах замын эмгэгүүдийн үеийн хүүхдийн протоколуудыг сайжруулахаар дадлага сургалт явагдсан. Тус сургалтын 5 дахь өдөр Монголд анх удаа хүүхдийн радиологийн чиглэлээр Хүүхдийн хавдарын зөвлөлийн хурал “Tumor Board” зохион байгуулж Монгол улсад оношилгоо эмчилгээ хийлгэсэн хорт хавдрын 5 ховор тохиолдлууд дээр гадаадын мэргэжилтнүүдтэй санал зөвлөлдөж оношилгоо эмчилгээний тактик боловсруулах, цаашдын хяналт зэргээр зөвлөгөө авч санал солилцсон. Уг үйл ажиллагаанд цус хавдар судлалын 5 эмч, мэс заслын нэг эмч, радиологийн нэг эмч, цөмийн оношилгооны нэг эмч нар Монгол талаас оролцсон. Мөн ХонгКонгийн хүүхдийн

эмнэлэгийн дүрс оношилгооны зөвлөх эмч Кевин Фунг өөрийн практикт оношлогдсон 4 ховор тохиолдын танилцуулгийг хийж санал солилцсон. Эдгээр өдрүүдэд нийт 46 удаагийн онолын болон сургалтын илтгэлүүд тавигдсан бөгөөд өдөр бүр 2 удаагийн кофе цай, нэг удаагийн үдийн хоолтой зохион байгуулагдсан.

Сургалтын эхний өдөр онолын мэдээллүүд эхлэхээс өмнө сургалтын өмнөх мэдлэгийг тестийн шалгалт авсан. Гурав дахь өдөр буюу онолын мэдээлэл дууссаны дараа сургалтын дараах тестийн шалгалтууд авсан. Уг шалгалтаар сургалтын өмнөх тестэнд нийт 68 хүн хамрагдсанаас 45,5%-тай дүгнэгдсэн бол сургалтын дараах тестийн шалгалтаар нийт 87 хүн өгснөөр 75% болж өссөн дүнтэйгээр амжилттай зохион байгуулагдсан. Эхний 3 хоног онолын сургалтанд 100% синхрон орчуулгатай явагдсан. Дараагийн 2 дадлага сургалтаар мөн мэргэжлийн орчуулагчтай явагдсан.

Зочин профессор илтгэгчид:

- **Жоанна Казниа Броун.** Их Британийн Бристолийн Их Сургуулийн дүрс оношилгооны зөвлөх эмч , Европийн дүрс оношилгооны Нийгэмлэг , Роял Коллеж, Хүүхдийн дүрс оношилгооны эмч, Хүүхдийн хавдрын дүрс оношилгооны эмч.
- **Кевин Фунг.** Хонг Конгийн Хүүхдийн эмнэлэгийн дүрс оношилгооны тасгийн зөвлөх эмч, Хонг Конгийн Их сургуулийн дэд профессор.
- **Мириам Майкл Леттэ.** Анагаах Ухааны доктор, Олон Улсын Цөмийн Энергийн Агентлагийн Нийгмийн Эрүүл Мэндийн хэлтэст Дүрс оношилгооны эмч.
- **Стив Лессэй.** Австралийн Мелбурн хотын Эмнэлгийн дүрс оношилгоо ба Цацрагийн Эмчилгээний Нийгэмлэгийн боловсрол хариуцсан захирал, Олон Улсын Дүрс Оношилгооны Технологичдын Нийгэмлэгийн боловсрол эрхэлсэн захирал.

Модератор эмч нар:

- **Д. Гончигсүрэн.** Монгол улсын хүний гавьяат эмч, АУ-ны доктор, профессор, Дүрс оношилгооны зөвлөх зэргийн эмч, Монголын Радиологийн нийгэмлэгийн ерөнхийлөгч.
- **Д.Дэлгэрцэцэг.** АУ-ны доктор, дэд профессор, Дүрс оношилгооны зөвлөх зэргийн эмч, ШУГТЭ Дүрс оношилгооны тасгийн эрхлэгч, ЭМЯ Радиологийн салбар зөвлөлийн дарга.
- **Ч.Баттулга.** Клиникийн профессор, Дүрс оношилгооны тэргүүлэх зэргийн эмч, ЭХЭМҮТ-ийн Радиологийн тасгийн эрхлэгч, Монголын Хүүхдийн Дүрс оношилгооны нийгэмлэгийн тэргүүн.
- **Д.Түвшинжаргал.** АУ-ны доктор, профессор, Дүрс оношилгооны тэргүүлэх зэргийн эмч, АШУҮИС-ийн Монгол-Япон сургалтын эмнэлэгийн Дүрс оношилгооны тасгийн эрхлэгч.

- **Э.Ундрах-Эрдэнэ.** АУ-ны доктор Канад улсын Dalhousie Их Сургуулийн дэд профессор, Интермэд эмнэлэгийн Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга.

Сургалтын үр дүнд хүүхдийн дүрс оношилгооны чадамж хүртээмж сайжирахаас гадна хүүхдийн цацрагийн аюулгүй байдлыг хангах мөрдөж ажиллах зэрэг технологич нарын ур чадвар сайжирна гэж дүгнэж байна.

ХАВСРАЛТ:


Өдөр нэг:



Зураг 1: Бүртгэл: Хурлын кит тараалт



Зураг 2: Синхрон орчуулгийн чихэвч тараах үйл ажиллагаа



Зураг 3: Хурлын зочид, төлөөлөгч нар.



Зураг 4: Хурлын нээлт. НҮБ-ийн Монгол дахь албан ёсны суурин төлөөлөгч

Өдөр хоёр, гурав:



Зураг 5: Онолын сургалтын явц



Зураг 6: Онолын сургалтын явц

Өдөр дөрөв:



Зураг 7: Дадлага сургалт.



Зураг 8: Хэт авиан хяналтан доорх хатгалт хийх арга техник. Дадлага сургалт.



Зураг 9: Сургалтын өмнө бэлдсэн фантомууд.



Зураг 10: Оролцогч нар дадлага хийж буй байдал.

Өдөр тав:



Зураг 11: Tumor Board. Өвчтөн танилцуулга:



Зураг 12: Tumor Board. Санал солилцох үйл ажиллагаа



Зураг 13: Tumor Board. Оролцогчид



Зураг 14: Хаалтын үйл ажиллагаа.